



МОНГОЛБАНК

**МОНГОЛ УЛСАД АЖИЛЛАЖ БУЙ ГАДААД
АЖИЛТНУУДЫН ЦАЛИНГИЙН СУДАЛГАА**

СУДАЛГААНЫ АЖИЛ


*Валют, Эдийн засгийн газрын
Төлбөрийн тэнцлийн статистик, судалгааны хэлтэс*

*эдийн засагч **Б.Мөнх-Эрдэнэ**
А.Цолмон
bor@mongolbank.mn*

I. УДИРТГАЛ, ЗОРИЛГО

Монголбанк нь төлбөрийн тэнцлийн статистикт гадаад ажилтнуудад төлсөн цалингийн зардлыг аж, ахуйн нэгж байгууллагын ТТ-1 маягт¹ болон банкуудын гадаад гүйлгээний мэдээлэлд үндэслэн тусгадаг.

Дүрслэл 1 МУ-ын Төлбөрийн тэнцлийн статистик. Гадаад ажиллагсдын цалин хөлс. сая ам.доллараар



Эх үүсвэр: Төлбөрийн тэнцлийн статистик

ТТ-1 маягтын дагуу мэдээлэл ирүүлдэг ААН-үүдийн дийлэнх нь гадаадын хөрөнгө оруулалттай уул уурхайн салбарын аж ахуйн нэгжүүд байдаг бөгөөд зам, барилга угсралтын салбарт ажиллаж буй харьяат бус ажилтнуудад² төлж буй нийт цалингийн зардал нь төлбөрийн тэнцэлд тусгагдаж буй эсэхийг тодруулах шаардлагатай болсон.

Иймд, харьяат бус ажилтнуудад төлж буй нийт цалингийн хэмжээг тодорхойлох, төлбөрийн тэнцлийн статистикийн хамрах хүрээг сайжруулахад энэхүү судалгааны зорилго оршино.

II. СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ

Судалгааны тайлангийн 3 дугаар бүлэгт Төлбөрийн тэнцлийн статистикийн гол эх сурвалж болох банкуудын гадаад гүйлгээгээр хийгдсэн цалингийн шилжүүлэгт шинжилгээ хийж, энэ төрлийн гүйлгээ нь аль салбарын компаниудаас, аль улсуудад хийгдэж байгааг тодруулав.

4 дүгээр бүлэгт Нийгмийн даатгалын ерөнхий газар, Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төвийн мэдээллийн санд үндэслэн манай улсад ажиллах зөвшөөрөл авсан болон нийгмийн даатгал төлж буй гадаад ажилтнуудын нийт цалин, ажиллаж буй салбар зэргийг тодорхойлсон. Түүнчлэн 2013, 2014 онд гадаадаас хамгийн ихээр ажиллах хүч авч ажиллуулсан компаниудаас анкетийн болон ярилцлагын аргаар цуглуулсан цалингийн мэдээллийг тусгалаа.

III. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН СТАТИСТИКИЙН ХОЛБОГДОХ ДАНСНЫ ШИНЖИЛГЭЭ

Хүснэгт 1 2013 оны Төлбөрийн тэнцэл дэх гадаад ажилтнуудын цалингийн зардал. Мэдээллийн эх үүсвэрээр. сая.ам доллар

	Мэдээллийн эх сурвалж	Хамрах хүрээ	Цалингийн зардал (\$)
1	ААН-ийн ТТ-1 мэдээ	Томоохон ААН-үүд	119
2	Банкуудын гадаад гүйлгээ	Бусад 404 ААН	117
Нийт Төлбөрийн тэнцэлд тусгасан			236

ААН - Аж ахуйн нэгж

Эх үүсвэр: Төлбөрийн тэнцлийн статистик. Монголбанк.

Үүний тал хувь буюу 119 сая ам.доллар нь томоохон ААН-үүдийн шууд тайлангаас, 117 сая ам.доллар нь 404 аж, ахуйн нэгж, төрийн байгууллага болон хувь хүмүүсээс банкаар дамжуулан гадаадруу хийсэн гүйлгээ бүртгэгдсэн байна.

Төлбөрийн тэнцлийн мэдээгээр 2013 онд Монгол Улсын аж, ахуйн нэгж байгууллагуудаас харьяат бус ажилтнуудад олгосон нийт цалингийн зардал 236 сая ам.доллар байна.

¹ Аж ахуйн нэгж, байгууллагын Төлбөрийн тэнцлийн тайлан.


² Монгол Улсад нэг жил ба түүнээс бага хугацаанд ажиллаж, амьдарч буй гадаад улсын ажилтан. Төлбөрийн тэнцлийн статистикт эдийн харьяат бусд төлж буй цалингийн зардлыг анхдагч орлогын дансанд бүртгэдэг.

2.1 Банкуудын гадаад гүйлгээ

Банкны гадаад гүйлгээгээр нийт цалингийн зардлын 68%-ийг уул уурхайн салбарын компаниуд, 12%-ийг барилга угсралт, 10%-ийг хувь хүнээс шилжүүлсэн гүйлгээ эзэлж байна.

2013 онд цалингийн гүйлгээ хийсэн нийт 404 компаниас жилд 16 мянган ам.доллараас дээш дүнтэй гүйлгээ хийсэн 166 компани байгаа бөгөөд нийт гүйлгээний дүнгийн 97%-ийг эзэлж байна. Эдгээр компаниудын 36% нь уул уурхайн салбарын, 23% нь барилга угсралтын томоохон компаниуд байна. Мөн Хятад ажилтнууд олноор ажилладаг зам угсралтын компани 5%-ийг эзэлж байна.

Дүрслэл 2 Компаниудын гадаад гүйлгээгээр шилжүүлж буй цалингийн дүн (салбарын ангилалаар)



Эх үүсвэр: Банкуудын гадаад гүйлгээний тайлан 2013


Хүснэгт 2 Гадаад гүйлгээгээр цалин шилжүүлсэн компаниудын тоо, салбарын ангилалаар.2013 он.³

Салбар	ААН-ийн тоо	%
Уул уурхай	59	36%
Барилга угсралт	38	23%
Гадаад худалдаа	16	10%
Хөнгөн үйлдвэр	11	7%
Зам угсралт	9	5%
Банк, санхүү	9	5%
Тээвэр	7	4%
Үйлчилгээ, харилцаа холбоо	6	4%
Барилгын үйлдвэр	3	2%
Төрийн байгууллага	3	2%
Боловсрол	2	1%
Зочид буудал	2	1%
ТББ	1	1%
Нийт	166	100%

Эх үүсвэр: Банкуудын гадаад гүйлгээний тайлан

Жижиг компаниуд буюу жилд 16 мянган ам.доллараас бага дүнтэй гүйлгээ хийсэн 238 компани байгаа нь нийт компаниудын 3%-ийг эзэлж байна. Эдгээр жижиг компаниудын дийлэнхи нь уул уурхай, барилга, замын компаниуд байна.

Дүрслэл 3 Хувь хүмүүсийн гадаад гүйлгээгээр шилжүүлж буй цалингийн дүн. (хүлээн авагч улсаар)



Эх үүсвэр: Банкуудын гадаад гүйлгээний тайлан 2013

Хувь хүмүүсийн данснаас хийсэн цалингийн төлбөр нь 2013 онд нийт цалингийн гүйлгээний 10% буюу 12 сая ам.доллар байна. Үүнээс гадаад нэртэй хувь хүмүүсээс хийсэн гүйлгээ 7%, монгол нэртэй хүмүүсээс хийсэн гүйлгээ нь 3% байна. Ийм төрлийн гүйлгээнүүдийн утгыг үзвэл компаниудын захирал, нягтлан бодогч нарын данснаас цалингийн төлбөр хийсэн тохиолдлууд байна.

³ Жилд 16 мянган ам.доллараас дээш гүйлгээ хийсэн ААН-үүдийг ангилал.

2.2 ТТ-1 мэдээ ирүүлдэг ААН-үүд

Хүснэгт 3 ТТ-1 мэдээ ирүүлдэг ААН-үүдийн 2013 оны нийт цалингийн зардал. Мянган ам.доллар

Салбар	Нийт цалин	ААН-ийн тоо
Уул уурхай	113,724	19
Гадаад худалдаа	4,989	6
Банк, санхүү	42	3
Үйлчилгээ	16	1
Нийт	118,771	29

Эх үүсвэр: Монголбанк

Төлбөрийн тэнцлийн тайланг Монголбанкинд ирүүлдэг компаниудын 29 нь эдийн засгийн харьяат бус ажилтнуудад цалин төлж байна. Тайлан ирүүлдэг компаниудын дунд олон тооны гадаад ажилчидтай барилга, замын компаниуд байхгүй тул түүвэр судалгаагаар энэ салбарын компаниудад голчлон анхаарал хандуулж гадаад ажилтнуудад төлж буй дундаж цалин, ажилтнуудын тоог тодорхойлохыг зорилоо.

IV. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Гадаад ажилтнуудад төлж буй нийт цалингийн зардлыг тооцоолохдоо судалгааны хамрах хүрээ, эх сурвалжийг нэмэгдүүлэх зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын мэдээллийн санд бүртгэгдсэн нийт цалингийн хэмжээг авч ашиглав. Түүнчлэн Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төвд бүртгэлтэй гаднаас ажиллах хүч авах зөвшөөрөл авсан компаниудаас анкетын болон ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулав.

3.1 Нийгмийн даатгалын мэдээллийн сан


Монгол Улсын Нийгмийн даатгалын тухай хуулийн 4-р зүйл⁴-д заасны дагуу аж ахуйн нэгж, байгууллагатай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж буй гадаадын иргэн нийгмийн даатгалд заавал хамрагдах ёстой. Иймд нийгмийн даатгалын ерөнхий газарт бүртгэгдсэн гадаад ажилтнуудын цалингийн мэдээллийг авч, Дүрслэл 4-т төлбөрийн тэнцлийн статистикт тусгасан эдийн засгийн харьяат бус ажилтнуудад төлсөн цалингийн зардалтай харьцууллаа.

Төлбөрийн тэнцлийн статистикт эдийн засгийн харьяат буст буюу Монгол Улсад 1 жилээс доош хугацаанд ажиллаж, амьдарсан ажилтнуудад төлсөн цалин бүртгэгдсэн.

Харин НДЕГ-ын мэдээлэлд эдийн засгийн харьяаллыг үл харгалзан Монгол Улсад оршин сууж буй нийт гадаадын иргэдийн цалингийн зардал орсон. Үүнээс эдийн засгийн харьяат бус ажилтнуудад төлсөн цалингийн зардлыг авч үзвэл одоогийн төлбөрийн тэнцлийн статистикаас бага байна. Энэ нь зарим компаниуд нийгмийн даатгалын шимтгэлээс зайлсхийдэг, эсвэл бодит цалинг бага дүнгээр мэдүүлсэн байх магадлалтайг илтгэж байна.

⁴ “...Монгол Улсын аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус, шашны болон бусад байгууллага, иргэнтэй хөдөлмөрийн гэрээний дагуу ажиллаж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн нийгмийн даатгалд хамрагдана...”

Дүрслэл 4 Монгол Улсад ажиллаж буй нийт гадаад ажилтнуудад төлсөн цалингийн зардал.
Нийгмийн даатгал, төлбөрийн тэнцлийн харьцуулалт



Эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар, Монголбанк

Хүснэгт 4 Нийгмийн даатгалын бүртгэл. Гадаад ажилтантай компани, ажилтнуудын тоо. Үйл ажиллагааны салбараар.

Салбар	2013		2014q1		Эзлэх хувь	
	Ажилтны тоо	Компаний тоо	Ажилтны тоо	Компаний тоо	Ажилтан	Компани
Уул уурхай	2,791	255	859	163	14%	8%
Худалдаа	2,646	637	1,172	510	14%	22%
Барилга	2,306	128	1,335	258	14%	7%
Тээвэр, агуулах холбоо	1,609	139	848	118	9%	5%
Сургууль	1,369	255	750	185	8%	8%
Үйлдвэр	1,097	206	690	184	7%	8%
ХАА	365	80	274	86	2%	3%
Эмнэлэг	267	84	184	66	2%	3%
ТББ, нийгмийн	208	71	102	54	1%	2%
Санхүү	152	64	117	47	1%	2%
Цахилгаан, хий, ус	105	28	49	21	1%	1%
Бусад, түрээс	5,937	977	1,485	584	28%	30%
Нийт	18,852	2,924	7,865	2,276	100%	100%

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар, Судлаачийн тооцоолол

Үүнээс, уул уурхай, худалдаа, зам, барилгын салбарын ажилтнууд нийт ажилтнуудын хамгийн их буюу тус бүр 14%-ийг эзэлсэн байна.

Хүснэгтэд үзүүлснээр НДЕГ-ын бааз дахь компаниудыг Үндэсний статистикийн хорооны бизнес регистрийн сангийн албан ёсны ангилалаар ангилсан бөгөөд зам угсралтын компаниудыг барилгын салбарт оруулсан. Харин “бусад, түрээс” ангилалд орсон компаниуд нь дээрх салбараас бусад төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг, мөн үйл ажиллагааны чиглэлийн мэдээлэл нь тодорхой бус жижиг компаниуд байна.

2013 онд нийт 2924 компаний 18852 гадаад ажилтан Нийгмийн даатгалд хамрагдан ажилласан байна. Харин 2014 оны 1-р улирлын байдлаар 2276 компаний 7865 ажилтан ажилласан.

Хүснэгт 5 Ажилтны тоо. Сарын дундаж цалингийн интервалаар. Төгрөг.

Салбар	2013					
	200 мян-аас бага	0.2 - 2 сая хүртэл	2-6 сая	6-10 сая	10-20 сая	20 сая-с дээш
Уул уурхай	472	1,225	140	58	182	714
Худалдаа	425	1,583	180	103	169	186
Барилга	1,336	949	13	5	1	2
Тээвэр, агуулах, холбоо	1,043	520	20	13	11	2
Сургууль	185	1,103	68	8	4	1
Үйлдвэр	319	692	48	17	13	8
ХАА	138	217	1	2	6	1
Эмнэлэг	54	190	11	8	4	-
ТББ, нийгмийн	53	153	2	-	-	-
Санхүү	11	88	21	21	5	6
Цахилгаан, хий, ус	2	93	7	1	-	2
Бусад, түрээс	2,510	2,953	241	89	80	64
Нийт	6,548	9,766	752	325	475	986
Эзлэх хувь	35%	52%	4%	2%	3%	5%

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар, Судлаачийн тооцоолол

Хүснэгт 6. 1 гадаад ажилтны 1 сарын жигнэсэн дундаж цалин. Төгрөг.

Салбар	1 ажилтны сарын дунд. цалин	
	2013	2014q1
Уул уурхай	4,019.5	5,002.7
Худалдаа	2,361.0	2,233.5
Барилга	864.7	900.0
Тээвэр, агуулах, холбоо	1,255.3	1,570.4
Сургууль	651.7	725.1
Үйлдвэр	930.6	1,300.0
ХАА	918.7	2,261.5
Эмнэлэг	603.1	938.3
ТББ, нийгмийн	373.7	464.5
Санхүү	3,339.2	5,288.4
Цахилгаан, хий, ус	2,680.0	946.8
Бусад, түрээс	1,435.5	2,045.5
Дундаж	1,783.6	2,100.9

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар, Судлаачийн тооцоолол

НДЕГ-ын мэдээллээр гадаад ажилтнуудын 52% нь сард дунджаар 200 мянгаас 2 сая төгрөгийн цалин, 35% нь 200 мянган төгрөгөөс бага цалин авчээ. 200 мянгаас 2 сая төгрөгийн хооронд цалин авч буй ажилтнуудын дийлэнхи нь уул уурхай, худалдаа, боловсролын салбарт ажиллаж байна.

Харин барилгын салбарын ажилтнуудын дийлэнхи буюу 58 хувь нь сард 200 мянган төгрөг буюу түүнээс бага цалин авдаг гэж мэдээлсэн байна.

Хүснэгт-5-д НДЕГ-ын мэдээллийн сан дахь гадаад ажилтны сарын дундаж цалинг дүнгийн интервал тус бүрээр нь жигнэж тооцон үзүүлээ.

Хүснэгт 6-д үзүүлснээр уул уурхайн салбарын ажилтан хамгийн өндөр буюу сард дунджаар 4 сая төгрөгийн цалин авч байна.

Харин барилга, боловсрол, төрийн бус байгууллага, нийгмийн салбарын ажилтнууд хамгийн бага цалинг авч байна. Төрийн бус, нийгмийн байгууллагын ажилтнууд нь шашны болон бусад сайн дурын зорилгоор, эсвэл олон улсын байгууллагын томилолтоор ирсэн байдаг.

Эдгээр ажилтнууд хуримтлал үүсгэх бус зөвхөн Монгол Улсад амьдрах хүнс, өдөр тутмын хэрэглээнд зарцуулах хэмжээний бага цалинг авч, нийгмийн даатгалын шимтгэл төлдөг байна. Харин гадаад ажилтнуудын тоогоор уул уурхайн салбартай зэрэгцэн хамгийн өндөр хувийг эзэлж байгаа барилгын салбарын ажилтнуудын дундаж цалин нь яагаад харьцангуй бага байгааг судалгааны дараагийн хэсэгт тодрууллаа.

3.2 Компаниудтай анкетын аргаар хийсэн түүвэр судалгааны үр дүн

Нийгмийн даатгалын мэдээллээр гадаад ажилтнуудын нийт цалингийн хэмжээ, ялангуяа барилгын салбарын ажилчдын цалингийн хэмжээ нь бодит зах зээлээс багаар үнэлэгдсэн байх магадлалтай гэсэн таамаглалыг дэвшүүлэн компаниудад түүвэр судалгаа зохион байгуулж салбарын дундаж цалинг тодорхойлохыг зорьсон.

Салбар бүрийн дундаж цалинг тооцоолоход гадаад ажилтан ажиллуулах зөвшөөрөлтэй компаниудын жагсаалт, нийт гадаад ажилтнуудын тоо шаардлагатай.

Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв нь 2013 онд Монгол Улсад гадаад ажилтан ажиллуулах 1428 компанид нийт 26109 ажилтны зөвшөөрөл олгосон нь нийгмийн даатгалд бүртгүүлж цалин авсан ажилтны тооноос 7300-аар илүү байна. Энэ нь манай улсад ажиллах зөвшөөрөл урьдчилан авсан ч ажиллаагүй, нийгмийн даатгалын ерөнхий газарт мэдээллээгүй, цалин авдаггүй гадаадын иргэд Монгол Улсад ажиллах зөвшөөрөл авч байгаа зэрэг олон хүчин зүйлсээс шалтгаалдаг болох нь компаниудтай хийсэн уулзалтаар батлагдсан. Мөн соёл, спортын чиглэлээр хамтарсан бэлтгэл хийх зорилгоор ирсэн гадаад иргэд ХЭҮТ-өөс ажил эрхлэх зөвшөөрөл авч байна.

Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авсан гадаад ажилтнуудын хамгийн олон буюу 52% нь барилга, замын компаниудад, 32% нь уул, уурхайн компаниудад ажиллах зөвшөөрөл авчээ.

Хүснэгт 7 Гадаад ажилтны сарын дундаж цалин. НДЕГ-ын мэдээлэл, ААН-ээс авсан түүврийн харьцуулалт. Ам.доллараар. 2013 оны дундаж.

Салбар	НДЕГ-ын баазаас	ААН-ээс авсан түүвэр	
		Биеийн хүчний ажилтан	Оюуны хөдөлмөр эрхлэгч
Уул уурхай	2,645.8	1,432.7	3,206.9
Худалдаа	1,564.2		
Барилга	590.7	318.3	4,192.6
Тээвэр, агуулах, холбоо	838.9		
Сургууль	441.9		800.0
Үйлдвэр	636.0	960.0	7,680.3
ХАА	625.8		
Эмнэлэг	425.1		
ТББ, нийгмийн	274.3		
Санхүү	2,202.8		6,130.1
Цахилгаан, хий, ус	1,762.6		
Бусад, түрээс	967.4		

Ам доллар/Төгрөгийн 2013 оны дундаж ханш 1,526

Эх үүсвэр: Монголбанкны түүвэр судалгаа, Нийгмийн даатгалын мэдээллийн сан.

2013 онд ажиллах зөвшөөрөл авсан нийт гадаад ажилтнуудын 20%, 2014 оны 1-р улирлын 37%-ийг бүрдүүлсэн томоохон 32 компаниас дундаж цалингийн мэдээллийг тодорхойлох зорилгоор анкет, уулзалтын аргаар мэдээлэл цуглуулсан. Түүвэрт уул уурхайн 9, барилга угсралтын 9, замын 4, үйлдвэрлэлийн 6, боловсролын 2, банк, санхүүгийн 2 компани хамрагдав.

Энэхүү түүврээс цуглуулсан биеийн хүчний ажил, оюуны хөдөлмөр эрхэлдэг ажилтан тус бүрийн сарын дундаж цалинг НДЕГ-аас авсан мэдээллийн дундаж цалинтай харьцуулан Хүснэгт 7-д үзүүлжээ.

Харьцуулалтаас харахад салбар бүрийн дундаж цалин нь хандлагын хувьд нийгмийн даатгалын мэдээлэлтэй төстэй буюу уул уурхайн салбарын ажилтнууд өндөр цалин авдаг бол барилга, үйлдвэрийн ажилтнууд хамгийн бага цалинтай гэж харагдаж байна.

3.2 Компаниудтай ярилцлагын аргаар хийсэн түүвэр судалгаа

Хүснэгт 8 Уулзалт хийсэн ААН-үүд

Компани	26
Барилга угсралт	14
Зам угсралт	6
Уул уурхай	3
Төмөр замын барилга	1
Төмрийн үйлдвэр	1
Хивсний үйлдвэр	1

Эх үүсвэр: Түүвэр судалгаа

Нийгмийн даатгалын мэдээлэл, анкетын аргаар авсан түүвэр судалгаагаар хамгийн олон гадаад ажилтантай зам, барилга угсралтын салбаруудын сарын дундаж цалингийн хэмжээ нь маш бага байгаа шалтгааныг тодруулах зорилгоор хамгийн их гадаад ажилтан ажлуулах зөвшөөрөл авсан 26 компаниас ярилцлага, анкетын хосолсон аргаар мэдээлэл цуглуулж, судалгаа хийлээ.

Ярилцлаганд хамрагдсан компаниуд нь 2013 онд Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төвөөс нийт 4947 гадаад ажилтан ажлуулах зөвшөөрөл авсан нь нийт зөвшөөрлийн 20%-ийг эзэлж байна.

Чанарын мэдээллүүд

Судалгааны үр дүнд бий болсон чанарын мэдээллүүдийг Хүснэгт 9, 10, -т үзүүлээ.

Хүснэгт 9 Аль улсын биеийн хүчний ажилтнууд ихэвчлэн ажиллаж байна вэ?

Компаний тоо	28
БНХАУ-ын ажилтантай	21
БНАСАУ-ын ажилтантай	7

Эх үүсвэр: Түүвэр судалгаа

Хүснэгт 10 Цалин олгодог хэлбэр

Компаний шинж чанар	ААН-ийн тоо	Цалин олгодог хэлбэр	Төлбөрийн тэнцэлд бүртгэх
1 Хятад ажилчидтай - БНХАУ-ын хөрөнгө оруулалттай.	9	БНХАУ-ын толгой компаниас Хятад ажилтнуудад цалин олгодог. Монгол Улсын ААН нь БНХАУ-руу барилгын үйлчилгээ, барилгын материалын импортын төлбөрүүд шилжүүлдэг	Үндсэн цалинг бүртгэхгүй. Барилгын үйлчилгээний төлбөрүүд бүртгэгдсэн
2 Хятад ажилчидтай - Дотоодын хөрөнгө оруулалттай	6	БНХАУ-ын компанид барилгын үйлчилгээний төлбөр шилжүүлдэг. Ажилчдад үндсэн цалин олгодоггүй. Зарим компаниуд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр Нийгмийн даатгалын хураамж төлдөг.	Барилгын үйлчилгээний дансанд бүртгэгдсэн
3 БНАСАУ-ын ажилчидтай	6	БНАСАУ-аас үүсгэн байгуулсан Монгол Улс дахь компаниудад ажлын төлбөрийг нийтээр төлдөг бөгөөд ажилтан бүрт үндсэн цалинг олгодоггүй. БНАСАУ-аас үүсгэн байгуулсан компаниуд нь Монгол Улсад нийгмийн даатгал бүртгэлтэй байдаг ба БНХАУ-руу шилжүүлж буй гүйлгээ нь банкуудын гадаад гүйлгээний дансанд туссан байдаг.	Ажилчдын цалин, хувийн гуйвуулгын дансанд бүртгэгдсэн
4 БНСУ-ын ажилтнуудтай	2	БНСУ-ын хөрөнгө оруулалттай компани толгой компани нь БНСУ-аас ажилтнуудынхаа цалинг олгодог.	Төлбөрийн тэнцэлд бүртгэхгүй
Нийт	23		

Эх үүсвэр: Түүвэр судалгаа

Хүснэгт 10-т гадаад ажилтнуудын цалинг хэрхэн олгодог талаарх чанарын мэдээлэл, төлбөрийн тэнцэлд бүртгэгдэж буй эсэхийг үзүүлээ. Компани тус бүрийн хувьд харилцан адилгүй нөхцөлөөр цалин түүнтэй холбоотой зардлыг гаргаж байна. Эдгээр тохиолдлуудыг дурдвал:

- Дотоодын барилгын компаниудын хувьд БНХАУ-ын барилгын үйлчилгээний компаниудтай захиалгаар барилга угсралт хийлгэх гэрээ байгуулж, үйлчилгээний төлбөрийг гадаад гүйлгээгээр шилжүүлж, ажилтан тус бүрт цалин төлдөггүй байна. Харин үйлчилгээ үзүүлж буй компанийн Хятад ажилтнуудын Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг өөрийн компанийн нэр дээр авч, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцон НДШ төлдөг.
- Хятад ажилчид үндсэн цалингаа Монголын компаниудаас авдаггүй, БНХАУ дахь толгой компаниудаасаа авдаг. Харин Монголд удаан хугацаагаар ажиллаж буй цөөн тооны инженер, удирдах ажилчдад өндөр цалинг олгож байна.
- Барилгын зарим компаниуд БНХАУ-ын ажилчдад Монголд байх үеийн хоол, хүнсний хэрэглээнд зориулан сард 200 мянга орчим төгрөгийн цалинг олгож, үүнээс нийгмийн даатгалын шимтгэл төлдөг.
- Зам угсралтын компаниудын дийлэнхи нь БНХАУ-ын 100 хувийн хөрөнгө оруулалттай байдаг бөгөөд зарим компаниуд нь сард дунджаар 800 мянган төгрөгийн цалинг олгодог.
- БНАСАУ-ын ажилчдыг Монгол Улсад оруулж ирэх зөвшөөрөл авч буй Монгол Улсын хуулийн этгээдүүд байна. Тус улсаас ирсэн эрэгтэй ажилчид нь барилга угсралтын компаниудад, эмэгтэй ажилчид нь хивс, оёдлын үйлдвэрүүдэд ажиллаж байна. Монгол компаниуд БНАСАУ-ын ажилчдад тус бүрт нь цалин олгодоггүй, ажлын гүйцэтгэлээр нь “бригадын удирдлагууд”, Монголд оруулж ирсэн компаниудад төлбөрийг нь олгодог. Эдгээр ажилчдад төлөх төлбөрийн зардал харьцангуй хямд байдаг бөгөөд 1 хүнд ногдох сарын дундаж цалин 100-200 ам.доллар байна.

Барилгын үйлчилгээний төлбөрийн гүйлгээнүүд, Хятад, БНАСАУ-ын ажилчдын цалингийн гуйвуулга нь банкны гадаад гүйлгээний мэдээнд туссан байгаа нь Монгол Улсын төлбөрийн тэнцлийн статистикт бүрэн хамрагдсан байна.

V. ДҮГНЭЛТ

Шинжилгээ, судалгааны үр дүнгээс үзвэл Монгол Улсад ажиллаж буй гадаад ажилтнуудын дийлэнхи нь уул уурхай, зам, барилгын салбарт ажиллаж байна. Харин дундаж цалингийн зардлын хувьд уул уурхайн салбарын ажилтнуудын цалин хамгийн өндөр буюу 2646 ам.доллар байгаа бол барилгын салбарын ажилтнууд харьцангуй бага буюу 590 ам.долларын цалинг авч байна.

Манай улсын барилга угсралтын компаниуд олон тоогоор Хятад ажилтан ажлуулах зөвшөөрөл авдаг ч үндсэн цалинг нь олгодоггүй бөгөөд зарим компаниуд хэрэглээний зардал болох сарын 200 мянга орчим төгрөгийг олгож, үүнээс нийгмийн даатгалын шимтгэл төлж байна. Учир нь манай улсын компаниуд Хятад компаниудаас барилгын үйлчилгээ авч, төлбөрийг банкны гадаад гүйлгээгээр төлж байна. Мөн БНХАУ-ын хөрөнгө оруулалттай барилгын компаниудад толгой компаниас нь ажилчдаа Монгол Улсруу томиллолтоор илгээн ажлуулдаг бөгөөд тэдгээр ажилчид нь өөрсдийн үндсэн цалингаа эх орондоо хүлээн авдаг. Эдгээр барилгын үйлчилгээнүүдийн зардал нь төлбөрийн тэнцлийн холбогдох дансанд бүртгэгдсэн бөгөөд 2013 онд 195 сая ам.доллар байна.

Одоогийн төлбөрийн тэнцлийн статистик бүртгэлийн аргачлал болох банкуудын гадаадын гүйлгээний тайлан, том ААН-үүдийн төлбөрийн тэнцлийн тайлангуудад Монгол Улсын ААН, байгууллагуудаас эдийн засгийн харьяат бус иргэдэд төлж буй нийт цалингийн мэдээлэл нь бүрэн хамрагдсан нь энэхүү судалгаанаас харагдаж байна.